



"ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН 2021 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу

Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг
Утас: 976-7013-1770
Гар утас: 9511-1770

Аудитор Ц.Алтанцэцэг
Гар утас: 9511-1770

Чанарын хяналтын аудитор А.Долгор
Гар утас: 99171199

Аудиторын туслах Ө.Зулцэцэг
О.Дэлгэрцэцэг
П.Мөнхзул
Г.Чулуунчимэг
Н.Гэрэлцэцэг
Б.Дэлгэржаргал

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Нарны
зам 81, JS tower 1002 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

Вэб хуудас: www.pma.mn

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл.....	2
Хараат бус аудиторын тайлан	3-6
Санхүүгийн байдлын тайлан	7
Орлогын тайлан	8
Мөнгөн гүйлгээний тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Компанийн товч мэдээлэл, танилцуулга	11-13
Тайлангийн хураангуй.....	14
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй	15-25
Санхүүгийн тайлангийн тодруулга.....	26-36
Санхүүгийн тайлангийн залруулга.....	37-40
Актуарчийн тайлан хавсралтаар	

**2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар
болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан
бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын
Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 7-10 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Шарын гол” ХК болон түүний охин компани “Нагай” ХХК, “Гавьлуу Уул” ХХК-иудын нэгтгэсэн санхүүгийн “ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь харуулах зорилгоор хийгдсэн болно.

Компаний удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно.

Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа СТОУС, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Шарын гол” ХК болон түүний охин компани “Нагай” ХХК, “Гавьлуу Уул” ХХК-иудын нэгтгэсэн санхүүгийн “ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Г.Хулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	М.Мэндсайхан Ерөнхий Захирал	Л. Эрдэнэжаргал Ерөнхий Нягтлан Бодогч
---	---	---

Улаанбаатар хот, Монгол улс
2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр

Огноо: 2022.03.01

№ Т-22/20.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Шарын гол” ХК болон түүний охин компани “Гавлуу уул” ХХК, “Нагай” ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь “Шарын гол” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 11-40 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг:

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх нүүрсний агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан. ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн ур чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн.

Мөн бид бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

Нөхөн сэргээлтийн нөөц:

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшнийг үнэлсэн.

Ажилчдын тэтгэврийн сангийн нөөц:

Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцоололтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг ул үндэслэлтэй гэж үнэлсэн.

Бусад мэдээлэл

Групп нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн

боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн багалгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хянаптыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж

аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



“Пантер Мидланд Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
"ШАРЫН ГОЛ" ХК		
(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)		
		(төгрөгөөр)
Үзүүлэлт	1/1/2021	12/31/2021
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,400,270,923.47	3,535,318,601.87
Дансны авлага	4,105,824,117.01	6,811,358,886.80
Татвар, НДШ-ийн авлага	0.00	125,553.21
Бусад авлага	47,003,088.15	998,382,354.30
Бараа материал	4,584,273,841.78	3,324,817,335.36
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,934,332,897.72	3,204,677,466.33
Эргэлтийн хөрөнгийн дүн	15,071,704,868.13	17,874,680,197.87
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	46,262,963,771.43	40,023,338,285.80
Биет бус хөрөнгө	17,504,472.71	522,329.46
Биологийн хөрөнгө	0.00	0.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,339,804,369.50	1,406,670,889.50
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	2,017,334,566.50	2,540,050,970.89
Хойшлогдсон татварын хөрөнгө	313,786,677.18	313,786,677.18
Бусад эргэлтийн бус хөрөнгө	18,713,865,831.00	18,246,257,141.32
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	68,665,259,688.32	62,530,626,294.15
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	83,736,964,556.45	80,405,306,492.02
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	6,391,265,283.49	8,518,180,982.38
Цалингийн өглөг	295,626,968.00	287,597,725.38
Татварын өр	6,702,134,201.50	6,409,776,306.36
НДШ-ийн өглөг	325,936,469.34	139,864,693.00
Богино хугацаат зээл	16,852,971,601.16	12,313,440,128.30
Хүүгийн өглөг	1,070,222,320.46	571,023,150.23
Ногдол ашгийн өглөг	376,142.95	376,142.95
Урьдчилж орсон орлого	61,388,963.33	804,501,580.02
Нөөц/өр төлбөр/	37,959,700.60	42,619,945.00
Бусад богино хугацаат өр төлбөр	4,262,172,113.56	3,578,689,615.97
Богино хугацаат өр төлбөрийн дүн	36,000,053,764.39	32,666,070,269.59
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	0.00	0.00
Нөөц/өр төлбөр/	16,910,128,897.70	16,369,781,897.70
Хойшлогдсон татварын өр	93,311,410.26	93,311,410.26
Бусад урт хугацаат өр төлбөр	10,933,883,951.26	6,963,258,452.43
Урт хугацаат өр төлбөрийн дүн	27,937,324,259.22	23,426,351,760.39
Өр төлбөрийн нийт дүн	63,937,378,023.61	56,092,422,029.98
Эздийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	1,017,024,200.00	1,017,024,200.00
- хувьцаат	0.00	0.00
Халаасны хувьцаа	0.00	0.00
Нэмж төлөгдсөн капитал	23,145,157,851.13	23,145,157,851.13
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,959,697,796.97	16,744,190,196.39
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(21,322,293,315.26)	(16,593,487,785.48)
Эздийн өмчийн дүн	19,799,586,532.84	24,312,884,462.04
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	83,736,964,556.45	80,405,306,492.02

12-40 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

"ШАРЫН ГОЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	1/1/2021	12/31/2021
Борлуулалтын орлого (цэвэр)	63,915,549,959.71	64,186,390,222.54
Борлуулалтын өртөг	58,670,381,014.08	55,694,194,944.95
Нийт ашиг (алдагдал)	5,245,168,945.63	8,492,195,277.59
Түрээсийн орлого	27,051,091.91	1,237,580,453.78
Хүүний орлого	9,470,236.41	1,777,455.23
Ногдол ашгийн орлого	0.00	0.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	2,410,478,678.80	264,302,027.64
Борлуулалт маркетингийн зардал	275,384,537.32	272,539,473.54
Ерөнхий ба удирдлагын зардал	2,373,628,964.03	1,873,026,923.25
Санхүүгийн зардал	1,779,823,876.66	1,653,739,478.83
Бусад зардал	4,660,510,629.32	1,680,874,175.39
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(654,575,886.93)	658,932,572.52
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	71,615,511.96	(234,865,208.30)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
Бусад ашиг (алдагдал)	3,858,394.79	0.00
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,976,281,034.76)	4,939,742,527.45
Орлогын татварын зардал	239,935,006.68	575,149,170.49
Татварын дараах ашиг (алдагдал)	(2,216,216,041.44)	4,364,593,356.96
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,216,216,041.44)	4,364,593,356.96
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
Бусад олз (гарз)	0.00	0.00
Орлогын нийт дүн	(2,216,216,041.44)	4,364,593,356.96
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

12-40 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"ШАРЫН ГОЛ" ХК		(төгрөгөөр)
(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)		
Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	63,334,753,054.79	67,342,245,684.54
Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого	62,638,478,567.75	63,260,227,258.89
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,062,708.79	9,766,965.60
Бусад мөнгөн орлого	694,211,778.25	4,072,251,460.05
Мөнгөн зарлагын дүн (-)	47,710,721,235.18	55,408,377,184.38
Ажилчдад төлсөн	9,341,400,552.30	7,411,597,950.22
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,241,287,767.66	2,064,539,295.19
Бараа материал худалдан авахад төлсөн	2,306,673,311.17	3,030,501,951.92
Ашиглалтын зардалд төлсөн	54,682.00	192,018,328.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,604,097,277.48	19,611,700,640.93
Хүүний төлбөрт төлсөн	821,282,769.20	1,582,848,706.81
Татварын байгууллагад төлсөн	2,763,104,985.23	4,758,759,968.88
Даатгалын төлбөрт төлсөн	135,432,925.07	96,694,371.85
Бусад мөнгөн зарлага	8,497,386,965.07	16,659,715,970.58
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	15,624,031,819.61	11,933,868,500.16
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	63,622,815.23
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	61,845,360.00
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
Хүлээн авсан хүүний орлого	0.00	1,777,455.23
Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,397,030,541.09	2,641,506,683.27
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,397,030,541.09	2,641,506,683.27
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(1,397,030,541.09)	(2,577,883,868.04)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	730,678,398.01	3,833,466,207.83
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	730,306,000.00	3,833,462,451.28
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн ашиг	372,398.01	3,756.55
Мөнгөн зарлагын дүн (-)	11,859,643,062.73	13,054,403,161.55
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	8,283,246,671.97	9,387,926,035.65
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,506,817,842.61	3,594,345,989.09
Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
Ханшийн тэгшитгэлийн алдагдал	69,578,548.15	72,131,136.81
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(11,128,964,664.72)	(9,220,936,953.72)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,098,036,613.80	135,047,678.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	302,234,309.67	3,400,270,923.47
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,400,270,923.47	3,535,318,601.87

12-40 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.

АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"ШАРЫН ГОЛ" ХК

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(төгрөгөөр)
					Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,157,200.00	23,145,157,851.13	15,736,199,912.80	(14,229,126,210.13)	25,669,388,753.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(2,216,216,041.44)	(2,216,216,041.44)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	(133,000.00)	0.00	0.00	0.00	(133,000.00)
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	1,223,497,884.17	(4,876,951,063.69)	(3,653,453,179.52)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	16,959,697,796.97	(21,322,293,315.26)	19,799,586,532.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	4,364,593,356.96	4,364,593,356.96
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	(215,507,600.58)	364,212,172.82	148,704,572.24
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,017,024,200.00	23,145,157,851.13	16,744,190,196.39	(16,593,487,785.48)	24,312,884,462.04

12-40 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

НЭГ. “ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Эдгээр тэмдэглэлүүд нь өмнөх санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- *Байршил: Дархан-Уул аймаг, Шарын гол, 3 дугаар бааг, Санжит, өөрийн байр*
Утас: 2235 И-мэйл:
- *Өмчийн хэлбэр: Хувьцаат Компани*
- *Харилцдаг санхүү, татварын байгууллага: Дархан-Уул аймгийн дүүргийн төрийн сан, татварын хэлтэс*
- *Тайлангийн хугацаа: 2021 оны 01 сарын 01-нээс 2021 оны 12 сарын 31*
- *Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*
 - ✓ Чулуун нүүрс олборлолт
- *Туслах үйл ажиллагаа:*
 - ✓ Туслах аж ахуй
 - ✓ Худалдааны зуучлал
 - ✓ Гадаад дотоод худалдаа
- *Өмнөх аудитор: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК, Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 16и дугаар хороо Амарсанаагийн гудамж -5 өөрийн байранд*
- *Аудитор: “Пантер Мидлан Аудит” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам JS тауэр 1002 тоот Утас: 70141770, 95111770*

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Шарын гол” ХК нь “Газрын баялгийг гүн боловсруулж, хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, харилцагчийн хэрэгцээг эрхэмлэнэ” гэсэн эрхэм зорилготой. Монгол улсын хууль, олон улсын сайн засаглалын стандарт болох хувьцаа эзэмшигчдийн эрхийг дээдэлж, компанийн засаглалд оролцогч талуудын хүлээх үүрэг хариуцлагын ил тод нээлттэй байдлыг хангах зарчмыг мөрдлөг болгон ажиллаж, компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бүрдүүлэн эдийн засгийн эрчимтэй хөгжлийг ханган олон улсын стандартад нийцсэн уул уурхайн компани болох стратегийн зорилгоо болгон ажиллаж байна.

Уурхай түүхийнхээ он жилүүдэд 61.2 сая.тн нүүрс олборлож, эх орныхоо түлш эрчим хүчний гол бааз суурь болж, эх орныхоо төвийн болон хойд бүсийн хэрэглэгчдийн гол голомтыг бадраах хар алтны хэрэгцээг тасралтгүй хангасаар байна.

Шарын голын уурхай нь Хэнтийн нурууны салбар Дархан уулын өвөрт Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос 240 км, Дархан хотоос 50 км-н зайтай оршино. Уурхай нь Улаанбаатар, Дархан хоттой төмөр зам, авто замаар холбогдсон. “Шарын гол” ХК нь Монголын анхны нүүрсний ил уурхай бөгөөд эх орныхоо түлш эрчим хүчний гол бааз суурь нь болж төвийн бүсийн дулааны цахилгаан станцууд болон бусад хэрэглэгчдийн хэрэгцээнд нүүрсээ нийлүүлж байна.

Нүүрсний нөөц

Уурхай нь 1827.9 акр талбайтай, 1498А тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

АМГ-р баталгаажуулж бүртгүүлсэн нөөц 192 сая тонн

В – Бодит зэргээр 64.06 сая.тн

С – Боломжит зэргээр 84.89 сая.тн

Бүтээгдэхүүний төрөл

Үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээнд тохируулан нүүрсээ хэмжээ фракц, илчлэг чанараар төрөлжүүлэн вагон болон авто машинаар худалдан борлуулалт хийдэг.

Нүүрсний төрөл: Хүрэн нүүрснээс чулуун нүүрсэнд шилжих үеийн В3 маркийн нүүрс

Бүтээгдэхүүний төрөл: 0-50мм нунтаг нүүрс, 50-300мм бүхэл нүүрс, 12-100мм баяжуулсан нүүрс

Нүүрс баяжуулах үйлдвэр

Нүүрс баяжуулах үйлдвэр нь 2015 оны 6-р сард ашиглалтанд орж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Үйлдвэр нь Гравитацын нойтон аргаар нүүрсийг боловсруулдаг ба Монгол улсын хойд бүс нутагт баригдсан анхны нүүрс баяжуулах үйлдвэр юм.

Үйлдвэрлэлийн хүчин чадал: жилд 600,000 тн

Гарах бүтээгдэхүүний илчлэг: 5000-аас дээш ккал.

Худалдан авагчид

Нийт олборлосон нүүрсний 93.7%-г төрийн өмчийн дулааны цахилгаан станцуудад, 2.6%-г аж үйлдвэр, үлдсэн 3.8%-г жижиг аж ахуй нэгж хувь хүмүүст борлуулалт хийдэг.

“Шарын гол” ХК-ийн хамт олон нь уул уурхайн мэдлэг чадвар, дадлага туршлага хуримтлуулсан 120 төрлийн ажил мэргэжлийн 460 орчим ажилтантайгаар олборлолт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн 78% нь үндсэн олборлолтод ажилладаг ба, 15% нь тэргүүний уурхайчин цол тэмдэгтэй, 67%-г дээд болон тусгай дунд боловсролтой ажилтнууд, 5%-г зөвлөх инженер, магистр зэрэгтэй ажилтнууд эзэлдэг. Нийт ажилчдын 69% нь тус компанид 4-өөс дээш жил тогтвор суурьшилсан ажилласан байна. “Шарын гол” ХК-с хөдөлмөрийн баатар 5, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон 5, гавьяат уурхайчин 9 алдартан төрөн гарсан байдаг.

Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10,170,242 ширхэг гаргасан энгийн хувьцаатай.

Гол хувь нийлүүлэгчид:

Эс Эйч Жи Холдингс 2 С.А.Р.Л	19.95%	2,028,906
Эс Эйч Жи Холдингс 3 С.А.Р.Л	19.80%	2,013,344
Нихан Холдингс С.А.Р.Л	15.72%	1,598,889
Үндэсний хөрөнгө оруулалтын банк	11.39%	1,158,520
Эс Эйч Жи Холдингс 1 С.А.Р.Л	11.24%	1,142,674
Могоул ресурсес Инк.	9.83%	1,000,000
ХААН банк	3.00%	305,107
Ж.Батбилэг	2.15%	218,902
Мехта Нитин	0.84%	85,000

Импера монголиа холдинг ХХК	0.71%	71,915
Бусад	5.37%	546,985
Нийт	100%	10,170,242

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 05 сарын 21-ний өдрийн №08 тоот тогтоолоор Г.Хулан ТУЗ-ийн даргаар томилсон. Компанийн ТУЗ-д үүсгэн байгуулагчдаас гадна дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлийн талаар туршлагатай мэргэжилтнүүд ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

Г.Хулан	ТУЗ-ийн дарга
Б.Батбаатар	ТУЗ-ийн гишүүн
Ж.Эрдэмбилэг	ТУЗ-ийн гишүүн
Ө.Хишигсүх	ТУЗ-ийн гишүүн
Б.Итгэлт	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Т.Говь-Дэлгэр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Б.Тулга	ТУЗ-ийн хараат бус гишүүн
М.Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
О.Цэндсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Ө.Энхтайван	(ТУЗ-ийн нарийн бичиг)

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 06 сарын 30-ний өдрийн №14 тоот тогтоолоор Х.Уянгыг “Шарын гол” ХК-ний гүйцэтгэх захиралаар томилон ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлага:

Х. Уянга	“Шарын гол” ХК-ийн гүйцэтгэх захирал
----------	--------------------------------------

“Шарын Гол” ХК-ийн ТУЗ-ийн 2016 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 13-р тогтоолоор “Буянтын хөндийн алтны шороон орд”-ын хил залгаа байршилтай, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “Нагай” ХХК-ийн хувьцааг худалдан авах гэрээг баталсан. “Нагай” ХХК нь Дархан-Уул аймгийн Шарын Гол сумын “Буянтын хөндий” нэртэй газар орших 354,4 болон 104.08 гектар талбайд хайгуул явуулах ДА-0004Х, ДА-0005Х дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Компани нь Нагай ХХК-ний хувьцааны 100 хувийг 425,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

“Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 10-р тогтоолоор “Гавьлуу Уул” ХХК-г байгуулагдахдаа Шарын Гол ХК-ийн албан ёсны хаяган дээр бүртгэлтэйгээр катерингийн үйлчилгээ болон гадаад дотоод худалдааны чиглэлээр үүсгэн байгуулахаар тогтоолыг баталсан. Компани нь Гавьлуу Уул ХХК-ний хувьцааны 100 ширхэг хувьцааг нэг бүр нь 10,000.00 төгрөгөөр 100 хувийг 1 сая төгрөгөөр үүсгэн байгуулсан

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь зөвхөн “Шарын гол” ХК болон түүний охин компани “Гавьлуу Уул” ХХК, “Нагай” ХХК-ийнх бөгөөд тоон мэдээллүүд нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг /MNT/-өөр илэрхийлэгдсэн байна.

ХОЁР. ТАЙЛАНГИЙН ХУРААНГҮЙ

“Шарын гол” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн завсар үеийн аудитыг 2021 оны 12 дугаар сарын 06-нөөс 2021 оны 12 дугаар сарын 16-ны хооронд, жилийн эцсийн тайлангийн аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 05-наас 2022 оны 1 дүгээр сарын 11-ны хооронд хийгдсэн.

Аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 02 дугаар сарын 27 хооронд гүйцэтгэж, захиалагч талд 2022 оны 02 дугаар сарын 28-нд хүргүүлэхээр төлөвлөн, “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор Ц.Алтанцэцэгээр ахлуулсан баг, чанарын хяналтын аудитор А.Долгор нар хариуцаж гүйцэтгэв.

“Шарын гол” ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Харин тэтгэврийн нөөц сан болон бусад нөөц сангуудын тооцооллыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын дагуу хөндлөнгийн актуарч Б.Баярмагнайгаар гүйцэтгүүлсэн болно.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нийт хөрөнгө, нийт орлого, нийт зардал гурваас нийт зардлыг сонгон суурь үзүүлэлт болгон сонголоо.

“Шарын гол” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгийн дүн 80,405,306.4 мянган төгрөг, нийт орлогын дүн **66,348,982.7** мянган төгрөг, нийт зардлын дүн **61,984,389.7** мянган төгрөг бөгөөд материаллаг байдлыг зардлыг суурь үзүүлэлт болгон үзэж 2%-иар тооцож **1,239,687.0** мянган төгрөгөөр тооцов.

“Шарын гол” ХК нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 29 өдрийн 170 тушаалаар батлагдсан “Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар” журмын дагуу тайлагнасан байна.

ГУРАВ. “ ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Тус компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримтална.

Нэгтгэсэн тайлан бэлтгэсэн үндэслэл

Нэгтгэлийн үндэслэл

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дагуу нэгтгэгч компани болох “Шарын Гол” ХК-ийн охин компаниудын тусдаа бэлтгэгдсэн санхүүгийн тайлангуудыг нэгтгэн илэрхийлж байгаа бөгөөд нэгтгэлд хамрагдаж буй тусдаа санхүүгийн тайлангууд нь ижил хугацаагаар тасалбар болж, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг бодлого баримтлан бэлтгэгддэг.

Групп нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ.

Санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй, санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг бөгөөд өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай. Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ. Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн болон түүний охин компаниудын (“Групп”) үр дүнг нэг аж ахуйн нэгж мэтээр тайлагнадаг. Иймд Компани болон охин компанийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүд болон үлдэгдлийг Сангийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 29 өдрийн 170 тушаалаар батлагдсан “Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар” журмын дагуу бүрэн цэвэрлэдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь бизнесийн нэгдлийн үр дүнг худалдан авалтын арга ашиглан нэгтгэдэг. Санхүүгийн байдлын тайланд нэгдэгчийн тодорхойлж болох хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр зэргийг олж авсан өдрөөрх бодит үнэ цэнээр тусгадаг.

Худалдаж авсан буюу олж эзэмшсэн компаниудын үйл ажиллагааны үр дүнг тухайн хяналт бий болсон өдрөөс эхлэн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг бөгөөд хяналтгүй болсон өдрөөс эхлэн нэгтгэлээс хасдаг.

Нэгтгэсэн Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг.

Нэгтгэсэн Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэлд нэмж тодруулсан.

Хэмжилтийн үндэслэл

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн:

- Санхүүгийн хэрэглүүр – бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Санхүүгийн хэрэглүүр - Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр
- Санхүүгийн хэрэглүүр - Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн хэрэглүүр - Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн өр төлбөр - Санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр

Тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн. Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Группийн удирдлага энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланг тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан бэлтгэсэн.

“Шарын Гол” ХК нь Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц ТӨХК, Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК зэрэг томоохон төрийн өмчит компаниудад Эрчим Хүчний Зохицуулах хорооны тогтоолоор баталсан зохицуулалттай үнээр нүүрсээ борлуулдаг.

Мөн групп нь Дархан-Уул аймгийн Шарын Гол сумын нутагт орших Буянтын хөндийн адаг хэсгийн алтны шороон ордын MV-001498 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд алт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа.

Компанийн 2013 онд батлагдсан ТЭЗҮ-ээр нүүрсний цаашид ашиглах нөөцийн хэмжээ нь ойролцоогоор 26,8 сая тонн гэж тогтоосон.

Группийн охин компани дахь эзэмшлийн хувийн өөрчлөлт

Охин компани дахь группийн эзэмшлийн хувийн өөрчлөлтийг охин компани дахь хяналтын багцаа алдаагүй л бол эзэмшигчийн өмчийн ажил гүйлгээ байдлаар бүртгэнэ.

Охин компани дахь группийн хувь эзэмшил болон хяналтын эрхгүй хувь оролцооны дансны үнийг эзэмшлийн хувьд гарсан өөрчлөлтөөр залруулдаг.

Хяналтын эрхгүй хувь оролцоон дахь өөрчлөлт ба төлсөн эсвэл хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг өмчид шууд хүлээн зөвшөөрч, компанийн эзэмшигчдэд хуваарилдаг. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд охин компанитай холбоотой бүртгэсэн өмнөх бүх дүнг тэдгээр хөрөнгийн данснаас хасалт байдлаар бүртгэнэ.

Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон

бусад стандартын нэмэлт өөрчлөл

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
-------	--	----------------

Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээ	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалуудыг дараах шинж чанаруудаар бүлэглэсэн байна. Бүлэг-1 Санхүүгийн тайлагналын зорилго Бүлэг-2 Санхүүгийн мэдээллийн хэрэгцээтэй байдлын чанарын үзүүлэлт Бүлэг-3 Санхүүгийн тайлан болон тайлагнагч аж ахуйн нэгж Бүлэг-4 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд Бүлэг-5 Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт Бүлэг-6 Хэмжилт Бүлэг-7 Толилуулга ба тодруулга Бүлэг-8 Капиталын талаарх үзэл баримтлал /ойлголт ба капитал загвар	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
СТОУС 3 Бизнесийн нэгдэл-Бизнесийн тодорхойлолт (2018 оны 10-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)	Бизнес гэж тодорхойлохын тулд хамгийн багадаа багц үйл ажиллагаа болон хөрөнгийг олж авсан байх. Орцыг иж бүрэн процессоор оруулж гарц бий болгодог байна гэж тодотгосон. Мөн үйлчлүүлэгчид бараа болон үйлчилгээг хүргэдэг байх гэж оруулснаас гадна өртөг зардал хэмнэх гэсэн хэсгийг хассан.	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга. НББОУС8 нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа	Материаллаг байдлын талаарх тодорхойлолтыг нэг ижил ойлголт болгохын тулд тухайлсан нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан. Шинэ тодорхойлолтоор мэдээллийг орхигдуулсан, буруу тайлагнасан, гуйвуулсан, бүрхэгдүүлсэн нь тухайн тайлагнагч аж ахуйн нэгжийн талаарх санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангуудад үндэслэн шийдвэр гаргадаг гол хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд нөлөөлнө гэж үзэж байвал материаллаг гэж авч үзнэ	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Компаний санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь компаний санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол компани эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрдөнө.

Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд:	Хэрэгжих хугацаа:
Нэмэлт өөрчлөлт орсон стандартууд	
СТОУС 3 <i>Бизнесийн тодорхойлолт</i> - үзэл баримтлалын хүрээний талаархи лавлагаа	2022 оны 1 сарын 1
НББОУС 1 ба НББОУС 8 <i>Материалын байдлын Тодорхойлолт</i> -	2020 оны 1 сарын 1
НББОУС 1 Урт болон богино хугацаат өглөгийн ангилал	2023 оны 1 сарын 1
СТОУС 10, НББОУС 28 <i>Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд хөрөнгө худалдах эсвэл хувь оруулалт</i>	Шийдвэр гараагүй
НББОУС 16- <i>Үндсэн хөрөнгө- Ашиглаж эхлэх хугацаанаас өмнөх үндсэн хөрөнгө бэлтгэл</i>	2022 оны 1 сарын 1
НББОУС 37- <i>Хүнд нөхцөлт гэрээ – Гэрээг биелүүлэх өртөг</i>	2022 оны 1 сарын 1
СТОУС-ийн 2018-2020 жилийн СТОУС-н ээлжит сайжруулалт СТОУС-уудын 2017 оны 12 дугаар сард хэвлэн гаргасан нэмэлт сайжруулалтууд <ul style="list-style-type: none"> • СТОУС 1- СТОУС анх удаа хэрэгжүүлэгч • СТУУС 9- хэрэгсэл 	2022 оны 1 сарын 1 2022 оны 1 сарын 1
Шинэ стандарт	
СТОУС 17 <i>Даатгалын гэрээ</i>	2023 оны 1 сарын 1

Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Групп нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг.

Үнэ цэнийн бууралт

Хөрөнгө эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

Эргэн төлөгдөх дүнг тогтоохдоо удирдлага нь группийн хэмжээний хөрөнгө тус бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашигладаг.

Группийн удирдлага нь тохирох хөнгөлөлтийн түвшнийг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг. Ихэнх тохиолдолд группийн удирдлага нь группийн хэмжээний үнэ цэнийн бууралтын шалгалтыг хийхдээ мэргэжлийн хараат бус үнэлгээчдийн тооцооллыг ашигладаг.

Бодит үнэ цэнийн хэмжилт

Группийн санхүүгийн тайлан дахь хэд хэдэн хөрөнгө, өр төлбөр нь бодит үнэ цэнийн хэмжилт, тодруулгыг шаарддаг. Группийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн хэмжилтэд ажиглагдахуйц өгөгдлийг аль болох их хэмжээгээр хэрэглэдэг.

Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Группийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

Хөрс хуулалтын зардал

Ил уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн үе шатанд хаягдлыг зайлуулах зардал гардаг. Үйлдвэрлэлийн үе шатанд, хөрс хуулалтын зардал нь тайлант хугацааны бараа материалын үйлдвэрлэл болон ирээдүйд олборлох хүдэрт нэвтрэх боломж болон уурхайн уян хатан байдлыг сайжруулж буйтай аль алинтай холбогдон гардаг.

Эхний хэсэг нь бараа материалын өртөгт шингэдэг бол сүүлийн хэсгийг тодорхой шалгуурыг хангасан үед хөрс хуулалтын хөрөнгөөр капиталжуулдаг.

Хөгжүүлэлтийн хөрс хуулалт болон үйлдвэрлэлийн хөрс хуулалтыг ялгахад томоохон үнэлэмж шаардагддаг бөгөөд үйлдвэрлэлийн хөрс хуулалт нь бараа материалыг гарган авах болон хөрс хуулалтын хөрөнгийг бий болгоход холбогдоно.

Уурхайн хөгжүүлэлтийн зардал

Уурхайн хөрөнгийг түүний бодит насжилтын хязгаар болон эдийн засгийн чадвар хоёрыг харгалзан жил бүр үнэлдэг. Энэ нь нөхөн төлөгдөх нөөц болон ирээдүйн хөрөнгийн зардлуудын тооцооллуудыг үнэлж үзэхийг шаарддаг. Хэрэв шинэ мэдээлэл олдвол, хийсэн тооцоолол, төсөөллүүд өөрчлөгдөж болно. Үйл ажиллагаа нь зогссон уурхайн хөгжүүлэлтийн хөрөнгө нь данснаас хасагддаг ба тухайн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд бусад зардлаар тайлагнана.

Нөхөн сэргээлтийн нөөцийн тооцоолол

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхэд ирээдүйд компаниас гарах зардлын тооцоо, мөн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх хугацаа, тооцоолсон хөнгөлөлтийн хувь хэмжээ зэргийг үндэслэн хөрөнгийг ашиглалтаас хасах үүргийн дүн болон холбогдох хөнгөлөлтийн хорогдуулгын дүнг тооцоолдог. Чухал ач холбогдолтой, шинэ мэдээлэл гарах бүрд тус компани ашиглалтаас хасах хөрөнгийн нөөцөд үнэлгээ хийж, шинэчилдэг. Гарах бодит зардал нь тооцоолсон дүнгээс өөр байж болно.

Мөн байгаль орчны хууль тогтоомжид ирээдүйд оруулж болзошгүй өөрчлөлтүүд нь компанийн хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг нэмэгдүүлж болно. Ирээдүйд гарах зардал өссөнөөр нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны зардлын хэмжээнд ихээхэн нөлөөлж болзошгүй. Ирээдүйн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны зардлын өнөөгийн үнэ цэнийг компанийн удирдлага хамгийн бодитой байдлаар тооцоолсны үндсэн дээр нөөцийг тодорхойлдог.

Нөөцийг тодорхойлоход ашигласан үндсэн төсөөллүүдийн аль нэг нь эсвэл зарим нь өөрчлөгдсөн тохиолдолд нөөцийн үлдэгдэл өртөгт ихээхэн хэмжээгээр нөлөөлж болно. Ашиглаж байгаа уурхайн ирээдүйн нөхөн сэргээлтийн зардлын өөрчлөлтийг санхүүгийн байдлын тайланд нөхөн сэргээлтийн хөрөнгө болон нөөцийг тохируулах байдлаар тусгах бөгөөд уурхайн ашиглалтын хугацаа эсвэл нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд үндэслэн элэгдүүлж, элэгдлийн зардлаар болон хөнгөлөлтийн хорогдуулалтын зардлаар дамжин ашиг, алдагдлын дүнд нөлөөлнө.

Хөрөнгийг ашиглалтаас хасах үүргийн дансны үнэ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 14,972,007 мянган төгрөг байна (2020 онд 12,686,728 мянган төгрөг байсан).

Хөрөнгийг ашиглалтаас хасах үүргийн дансны үнийг тооцоолохдоо ашигласан үндсэн төсөөллүүдийг доор хураангуйлан тодорхойлов.

- ✓ Мөнгөөр төлөгдөх зардлын хүлээгдэж байгаа хугацаа нь 2035 он хүртэл тооцсон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөтэй бөгөөд уг төлөвлөгөөнд үндэслэсэн.
- ✓ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар эрсдэлгүй хөнгөлөлтийг 10.34 хувь гэж тогтоосон.

Уурхайн нөөцийн тооцоолол

Уурхайн нөөц нь Группийн эзэмшлийн нийт олборлох өмчөөс хуулийн болон эдийн засгийн хувьд олборлож болохуйц уурхайн байгалийн нөөцийн дүнгийн тооцооллын дүнг илэрхийлдэг. Групп нь олборлох нөөцийн хэмжээ, гүн, хэлбэр зэргийн талаарх геологийн мэдээлэлд үндэслэн тусгай мэргэшсэн хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлсэн судалгааны тайланд үндэслэн уурхайн нөөцийг тооцоолдог. Байгалийн нөөцийн тооцоололд орсон өөрчлөлт нь хайгуул, үнэлгээний хөрөнгө,

уурхайн байгууламж, өмч, барилга, тоног төхөөрөмж, гүүдвилл, нөхөн сэргээлтийн нөөц зэргийн дансны үнэ болон хойшлогдсон татвар, элэгдэл, хорогдлын зардал зэрэгт нөлөөлдөг.

Эргэн нөхөгдөхөөр тооцоолсон нөөц нь олборлолттой холбоотой хөрөнгийн элэгдэл, шавхагдлыг тодорхойлоход ашиглагддаг. Энэ нь уурхайн үйлдвэрлэлийн таамаглаж буй үлдэх хугацаанд тэнцүү хэмжээгээр хорогдох нөөцийн хэмжээнд нөлөөлдөг. Эдийн засгийн хувьд болон биет байдлаар ашиглах боломжит нөөцийн хэмжээг жил бүр үнэлдэг. Энэхүү тооцоолол нь эргэн нөхөгдөх нөөцийн хэмжээ болон ирээдүйн капитал зарцуулалтын тооцоолол, таамаглалд суурилдаг.

Хойшлогдсон орлогын татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйн татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тайлант үе бүрийн эцэст шалгадаг бөгөөд үүнийг ирээдүйд хангалттай татварын өгөөж хүртэх боломжгүй болсон үед бүхлээр нь эсвэл хэсэгчлэн бууруулдаг. Үүнийг хэмжих магадлал нь хүлээгдэж буй ирээдүйн гүйцэтгэлд суурилан үнэлэгддэг. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн ирээдүйн ашиглалтын магадлалыг үнэлэхэд олон төрлийн хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай.

Үүнд: өмнөх үеийн үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөө, татварын стратеги төлөвлөлт болон цаашид шилжүүлэн тооцох татварын алдагдлын дуусгавар хугацаа зэрэг болно. Хэрвээ бодит үр дүн нь тооцоологдсон дүн эсвэл тооцооллоос өөр байвал энэ нь ирээдүйн үеүдэд санхүүгийн байдлын тайланд залруулагдах бөгөөд мөнгөн гүйлгээ болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө нь хойшлогдсон татварын хөрөнгийг ирээдүйд шилжүүлэх үнэлгээ буурах бөгөөд энэхүү бууралтыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Болзошгүй өр төлбөр

Ирээдүйн нэг буюу түүнээс олон тодорхойгүй үйл явдал бий болсон тохиолдолд болзошгүй өр төлбөрүүдүүсдэг. Ирээдүйн үйл явдлын үр дүнгийн талаарх дүгнэлтийн хэрэглээ, үр ашигтай шийдлийг хэрэгжүүлэх зэрэг нь болзошгүй байдал оршин буй эсэхийн үнэлгээ болдог.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Групп нь касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Дансны авлага

Группийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн,

үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Бусад авлага

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

Бараа материал

Группийн хэмжээнд бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Цэвэр боломжит үнэ цэнийг тооцохдоо тооцоолол хийх үеийн хамгийн найдвартай бэлэн байгаа нотолгоог авч үздэг. Группийн бизнес нь технологийн өөрчлөлттэй нягт уялдаатай бол борлуулалтын үнэ нь хурдан өөрчлөгдөхөд хүргэнэ. Бараа материалын дансны үнийн ирээдүйд гарах өөрчлөлт нь зах зээлийн сегмент бүр дэх үнийн өөрчлөлтөөс шалтгаална.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна.

Үүнд:

- (a) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;
- (б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;
- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;

- (г) Тээврийн хэрэгсэл: Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;
- (е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд;
